



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

**Албан даалгавар хэрэгжүүлэх
тухай**

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 02 тоот “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” албан даалгавар, Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газрын 2017 оны 01/177 тоотыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь.

1.Төсөвт байгууллагын удирдлага болон албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, дэг журам, хүн нэг бүрийн идэвхи санаачилгыг өрнүүлэх, зарцуулсан хөрөнгө, гарсан шийдвэр нэг бүрийн үр дүнг бодитой тооцож ажиллахыг нийт эмч ажилчдад анхааруулсугай.

2.Нийт эмч ажилчдын сахилга хариуцлагыг өндөржүүлж, гал, ус, газар хөдлөлт зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм журам, заавар зөвлөмжийг баримтлан эмчилгээ үйлчилгээний стандартуудыг хатуу мөрдөж, үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг сайжруулж ажиллахыг нийт эмч ажилчдад үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн төв болон поликлиник, салбар амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, Өрхийн Эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлж буй ард иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчилж, зөрчил гаргасан ажилчдад захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухайгаа холбогдох иргэд болон ажилчдад мэдээлж байхыг хүний нөөцийн менежер /Ц.Энхбаясгалан/-д даалгасугай.

4. Нийт эмч ажилчдын ирцийн бүртгэл, цаг ашиглалт, нийтийг хамарсан ажилд оролцсон байдал, захиргааны чөлөө олголт, эмнэлгийн хуудас, эмчийн магадлагаа зэргийн судалгааг нарийвчлан гаргаж цалинтай тооцож, ажил дүгнэж урамшуулал олгоход дүгнэлт хийж тооцож байхыг тасаг нэгжийн дарга нар болон хүний нөөцийн менежер /Ц.Энхбаясгалан/ нарт үүрэг болгосугай.


5.Хурал болон эмч, сувилагч нарын шуурхай зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнд өөрийн биеэр ирж ажил хэрэгч оролцож, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцрох, таслахгүй, нийтээр тэмдэглэх баяр ёслол болон

амралтын өдрүүдэд ба ажлын бус цагаар гар утасаа нээлттэй байлгаж, онцгой тохиолдолд ажиллахад бэлэн байх, цаг үеийн үүссэн нөхцөлд байдалтай уялдуулан өгсөг үүрэг даалгаврыг ажилтан бүр шуурхай зохион байгуулж, ажлын явц үр дүнг тогтоосон хугацаанд танилцуулж байхыг ний эмч ажилчдад үүрэг болгосугай.

6.Эмчилгээ үйлчилгээний үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй хууль тогтоомж, стандартын дагуу тавих байнгын хяналтыг эрс сайжруулж, тогтоосон стандарт, цагийн хуваарийг мөрдлөг болгон сахиулж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож арилгуулах арга хэмжээг түргэн шуурхай авч ажиллахыг ажил хариуцсан дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

7.Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дотоодын хяналтын мэргэжилтэн /Н.Эрдэнэсүвд/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ